Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны...дугаар Улаанбаатар
...сарын...ны өдөр хот

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/7[1] дүгээр зүйл

“7[1] дүгээр зүйл.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан

7[1].1.Нийслэл хотын газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг орон сууцжуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сантай байна.

7[1].2.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7[1].2.1.орон нутгийн төсөв;
7[2].2.2.гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болсон орон сууцыг худалдан борлуулснаас олсон орлого;

7[1].2.3.газрын дахин төлөвлөх хүрээнд газрыг дуудлага худалдаагаар худалдан борлуулсан орлого;

7[1].2.4.хуулиар хориглоогүй хандив, тусламж, бусад.

7[1].3.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

7[1].3.1.инженерийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгох, гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн нөхөх олговрын зардал;

7[1].3.2.айл, өрхийн гэрийн дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

7[1].3.3.ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгах, шинээр барих;

7[1].3.4.орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасын хүүгийн зөрүүг төлөх.

7^1.4.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

7^1.5.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн дүрмийг нийслэлийн Засаг дарга батална.

7^1.6.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн тайлан, зарцуулалт ил тод, нээлттэй байна.

2/18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт:

18.1.8.мэдээллийн систем, хиймэл оюун ашиглаж замын хөдөлгөөний урсгалыг оновчтой зохион байгуулах, түгжрэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, зөрчил илрүүлэх, ослын хяналтыг сайжруулах;

3/19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалт:

19.2.5.замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх автоматжуулсан системийг хариуцан ажиллах;”

2 дугаар зүйл.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “автобусны” гэснийг “автобус, таксины” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “үйл ажиллагааг” гэснийг “үйл ажиллагааг Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан болон” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “зарцуулна.” гэснийг “болон Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор борлуулна.” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтын дугаарыг “18.1.9” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалтын дугаарыг “19.2.6” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг